



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийг балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168, 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Увс аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн балансын үнэ, 4,997,718.70 (дөрвөн сая есөн зуун ерэн долоон мянга долоон зуун арван найман төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0245 дугаар ангид хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Хилийн цэргийн 0245 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Я.Гантөмөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

130001130  
И-р huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 6 дугаар сарын 10 ны өдрийн  
6 дугаар тогтоолын хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН УВС АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН УВС АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР /хуучин нэрээр/-ЫН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦЭРГИЙН  
0245 ДУГААР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Приус-30 автомашин, 78-03 УВА /арал-zvw300128211/	2010/2020	ш	1	15,000,000.00	4,997,718.70	10,002,281.30
	Нийт дүн				15,000,000.00	4,997,718.70	10,002,281.30